

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн нэр	3
1.2. Төслийн зорилго	3
1.3. Төсөл хэрэгжүүлэгч	3
1.4. Төсөл хэрэгжих талбайн байршил	3
1.5. Төслийн хүчин чадал, барилга байгууламж	4
1.6. Төсөл хэрэгжих талбайн дэд бүтэц	9
БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	11
1.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлт	11
1.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	11
1.3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт	13
1.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	15
1.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	15
1.6. Хог хаягдлын менежментийн биелэлт	15
2.1. 2022 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	22
2.3. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	24
ДҮГНЭЛТ	28

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төсөл хэрэгжих талбай орчмын тойм зураг.....	3
Зураг 2. Төслийн талбай орчмын өнөөгийн байдал.....	4
Зураг 3. Төв барилга	4
Зураг 4. Гэр сууц.....	5
Зураг 5. Гэр сууцын дотоод тохижилт.....	5
Зураг 6. Tiny house – амрагчдын байр	5
Зураг 7. Рестораны доторх орчин	6
Зураг 8. Вип лоунжийн хэсэг	6
Зураг 9. Өөрөө өөртөө үйлчлэх хэсэг /шорлог хийх/.....	6
Зураг 10. Хүүхдийн тоглоомын цогцолбор.....	7
Зураг 11. Хүүхдийн дотор тоглоомын цогцолбор	8
Зураг 12. Хүүхдийн гадна тоглоомын цогцолбор.....	8
Зураг 13. Ариун цэврийн байгууламж.....	8
Зураг 14. Ариун цэврийн байгууламжийн дотоод зохион байгуулалт	9
Зураг 15. Авто машины зогсоолын талбай.....	9
Зураг 16. Усны тоолуур суурилуулсан байдал, худгийг тохижуулсан байдал.....	12
Зураг 17. Анхан тусламжийн эмийн сан	12
Зураг 18. Галын наадмын талбайг аюулгүй ажиллагааны дагуу засаж тохижуулсан байдал	12
Зураг 19. Мод, сөөгний суулгац буулгасан байдал, шинээр тарималжуулалтыг ажлыг гүйцэтгэсэн байдал /Хайлаас/	13
Зураг 20. . Мод, сөөгний суулгац буулгасан байдал, шинээр тарималжуулалтыг ажлыг гүйцэтгэсэн байдал /бусад мод, бут/.....	14
Зураг 21. Амрагчдын сууцуудыг холбосон хатуу хучилттай зам байгуулсан байдал	14
Зураг 22. Төслийн талбай болон түүний орчмын цэвэрлэгээг тогмол хийх.....	15
Зураг 23. Ахуйн хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг, битүүмжилсэн байдал	16
Зураг 24. Ахуйн хатуу хог хаягдлын түр цэг байгуулахдаа хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савнууд, хаягжуулсан байдал.....	16
Зураг 25. Төслийн талбай болон түүний орчмын цэвэрлэгээг хийж буй байдал	17
Зураг 26. Хог хаягдлын гэрээний хуулбар	19
Зураг 27. Хог хаягдал зайлуулах үйлчилгээний төлбөрийн баримт.....	19
Зураг 28. Бохир ус зайлуулах гэрээний хуулбар.....	21
Зураг 29. Бохир ус зайлуулах үйлчилгээний төлбөрийн баримт.....	22
Зураг 30. Агаарын чанарын хэмжилтийн хийж буй үеийн зураг	25
Зураг 31. Төслийн талбайд байрлах гүнийн худгийн байршил	25
Зураг 32. Төслийн талбайд байрлах гүний худаг.....	26
Зураг 33. Хөрсний дээж авсан байдал, зүсэлтийн зураг.....	26

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн координат	3
Хүснэгт 2. Агаарын чанарын хэмжилтийн үр дүн.....	24
Хүснэгт 3. Судалгааны талбайн гүний худгийн солбилцол	25
Хүснэгт 4. Усны эрүүл ахуйн задлан шинжилгээний дүн	26
Хүснэгт 5. Хөрсний дээж авсан цэг	27
Хүснэгт 6. Хөрсний механик бүрэлдэхүүн	27
Хүснэгт 7. Хөрсний химийн шинж чанар	27
Хүснэгт 8. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж.....	27
Хүснэгт 9. Хөрсний эрүүл ахуй	27
Хүснэгт 10. БОМТ-ний биелэлтийн зардал, 2022 он.....	28

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

“Горхи ресорт” гэр бүлийн эко аялал жуулчлалын бааз төсөл

1.2. Төслийн зорилго


Хүрээлэн буй байгалийн үзэсгэлэн гоог тодотгох орчин цагийн контемпорари хэв маяг бүхий 100 хувь эко амралтын газрыг бүтээн байгуулж гэр бүлийн бүх гишүүдийн эрүүл, идэвхтэй амралтанд зориулсан олон төрлийн үйл ажиллагааг олон улсын стандартын түвшинд нэвтрүүлсэн жишиг эко ресорт бүхий амралтын газрыг бий болгон түүний ашигт байдал болон ажлын байрыг нэмэгдүүлэх, цаашид тогтвортой үйл ажиллагааг ханган ажиллахад төслийн гол зорилго оршино.

1.3. Төсөл хэрэгжүүлэгч

Төсөл хэрэгжүүлэгч: “Мандах консалтинг” ХХК
Улсын бүртгэлийн гэрчилгээ: 9011606069
Регистрийн дугаар: 5511119
Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, 20-23 тоот,
Холбоо барих: 99094370

1.4. Төсөл хэрэгжих талбайн байршил

Налайх дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын Өвөр горхийн аманд 2.5 газарт хэрэгжинэ.



Зураг 1. Төсөл хэрэгжих талбай орчмын тойм зураг

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн координат

	Уртраг	Өргөрөг
1	107°21'36.67"	47°49'02.83"
2	107°21'33.06"	47°49'04.43"
3	107°21'40.68"	47°49'11.77"
4	107°21'44.23"	47°49'09.66"



Зураг 2. Төслийн талбай орчмын өнөөгийн байдал

1.5. Төслийн хүчин чадал, барилга байгууламж

Тус гэр бүлийн эко ресорт нь гэр 30 гэр бүл хүлээн авах хүчин чадалтай. Амралтын газрын төв барилга нь газраас хөндий, контейнераар барьсан.

1. Иж бүрэн тохижуулалттай 18 эко монгол гэр
2. Нэг дор 100 хүн хүлээн авах хүчин чадалтай зоогийн газар
3. Өөрөө өөртөө үйлчлэх шорлог хийх цэг
4. Амарч тухлах VIP лоунж бүхий 2 давхар үйлчилгээний төв
5. Хүүхдийн тоглоомын төв
6. Ариун цэврийн байгууламж
7. Авто машины зогсоол



Зураг 3. Төв барилга



Зураг 4. Гэр сууц



Зураг 5. Гэр сууцын дотоод тохижилт



Зураг 6. Tiny house – амрагчдын байр





Зураг 7. Рестораны доторх орчин



Зураг 8. Вип лоунжийн хэсэг




Зураг 9. Өөрөө өөртөө үйлчлэх хэсэг /шорлог хийх/

Эко гэр бүлийн ресорт нь хүүхдэд ээлтэй, улалмжлалт аж ахуйг харуулсан үндэсний тоглоом наадгай, сэтгэн бодох чадвар хөгжүүлэх, гэр бүлийн бүх гишүүдийг хамтарч тоглох хүүдүүдтэйгээ илүү ойр байх нөцлийг бүрдүүлсэн, хүүхэд, багачууд болон гэр бүлийн зугаатай, бүтээлч цагийг дэмжих гадна болон дотор тоглоомын талбайг тохижуулсан байна.

- ✓ Хүүхдийн эко дотор тоглоомын цогцолбор
- ✓ Хүүхдийн эко гадаа тоглоомын цогцолбор
- ✓ Иж бүрэн цэцэрлэгжүүлсэн гадна тохижилт
- ✓ Гэр бүлийн урлан
- ✓ Эцэг эхийн амрах булан



Зураг 10. Хүүхдийн тоглоомын цогцолбор





Зураг 11. Хүүхдийн дотор тоглоомын цогцолбор



Зураг 12. Хүүхдийн гадна тоглоомын цогцолбор

Тус гэр бүлийн эко ресорт амралтын газар нь хоёр хэсэг ариун цэврийн байгууламжтай ба агаар сэлгэлт сайтай байгаль орчинд ээлтэй баррилгын материал ашигласан байна. Нарны эрчим хүч ашиглаж халуун ус хэрэглээг хангаж байна. Амрагчид өглөө 8-10 цаг орой 18-20 цагийн хооронд халуун усанд орох боломжтой.



Зураг 13. Ариун цэврийн байгууламж



Зураг 14. Ариун цэврийн байгууламжийн дотоод зохион байгуулалт

Автомашинны зогсоолын талбайг төслийн эдэлбэр газрын гадна талд хайрган хучилт хийж зассан байна.



Зураг 15. Авто машины зогсоолын талбай

1.6. Төсөл хэрэгжих талбайн дэд бүтэц

Цахилгаан хангамж: Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт байрлах Стройка ХХК-ийн 35/0.4 кВ-ын 100кВА чадалтай АТП-с Мандах консалтинг ХХК нь 0.4 кВ-ийн цахилгаан эрчим хүч татаж, ашиглах болон 35кВ-ын ЦДАШ-с салбарлан цахилгаан хэрэглээг хангадаг.

Зам харилцаа: Улаанбаатар-Тэрэлжийн хатуу хучилттай замаас 500 орчим метр шороон замаар явж тус Горхи ресорт эко гэр бүлийн амралтын газарт хүрнэ.

Цэвэр усны хангамж: Төслийн талбай дахь унд ахуйн зориулалт бүхий өөрийн гүний худгаас хангана.

Харилцаа холбоо: Утсан холбоонд үүрэн телефон холбоог ашиглах боломжтой бөгөөд дотоод сүлжээний систем, барилгын автомат хяналтын систем, дохиолол хамгаалалтын систем байна.

Дулаан хангамж: Амрагчдын сууц тус бүрт шалны халаагуур суурилуусан байна.

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

1.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төсөл хэрэгжүүлэгч “Мандах консалтинг” ХХК-иас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах баримт бичиг юм.

2022 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Монгол улсын Байгаль хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох журам дүрэм, 2022 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан зэргийг үндэслэн БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлан боловсруулсан болно.

2022 онд байгаль хамгаалах арга хэмжээ, орчны тохижилт, хог хаягдлын менежментийн хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд ногоон байгууламж нэмэгдүүлэхэд анхаарч монос, нарс, агч, өрөл, хайлаас зэрэг нийт 1150 ш навчит, шилмүүст болон жимсний мод, бутыг суулгах, арчилах, зүлэгжүүлэх, амрагчдын сууцуудыг холбосон зам талбайг хатуу хучилттай болгох, төслийн талбай, түүний орчмын цэвэрлэгээг тогтмол хийх, ахуйн хог хаягдал хуримтлуулах савыг засварлах, ангилан ялгах зориулалтын сав байршуулах, хог хаягдлын гэрээг шинэчлэн хогны төлбөрийг төлөх, газрын төлбөр төлөх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

1.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

2022 онд хэрэгжүүлсэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт:

БОМТ тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Биелэлт	Зардал, төгрөг	Төсөл хэрэгжүүлэгч, /хамтран хэрэгжүүлсэн/
Гүний худагт тоолуур суурилуулах	Гүний худагт тоолуур суурилуулсан.	150,000	“Мандах консалтинг” ХХК
Худгийн байрыг барьж, засаж тохижуулах	Худгийн байр байгуулсан.	300,000	“Мандах консалтинг” ХХК
Ус ашигласны төлбөрийг төлөх	Тоолуурын заалтаар сар бүр тогтмол төлдөг.	Үйл ажиллагааны зардалд орсон.	“Мандах консалтинг” ХХК
Борооны ус хуримтлуулж ногоон байгууламж усалгаажуулах, дуслын усалгааны системийг ашиглаж ногоон байгууламжийг услах	Борооны ус хуримтлуулж ногоон байгууламж усалгаажуулах, дуслын усалгааны системийг ашиглаж ногоон байгууламжийг услах систем суурилуулаагүй. 2023 онд хэрэгжүүлэх БОМТ-нд тусгах болно.	0,0	“Мандах консалтинг” ХХК
Ажлын байранд эмийн сан бий болгох	Ажлын байранд эмийн сан байршуулсан. /3 ш /	300,000	“Мандах консалтинг” ХХК
Галын наадмын талбайг аюулгүй ажиллагааны дагуу засаж тохижуулах	Галын наадмын талбайг аюулгүй ажиллагааны дагуу засаж тохижуулсан.	4,000,000	“Мандах консалтинг” ХХК
Нийт дүн		4,750,000 төгрөг	



Зураг 16. Усны тоолуур суурилуулсан байдал, худгийг тохижуулсан байдал



Зураг 17. Анхан тусламжийн эмийн сан



Зураг 18. Галын наадмын талбайг аюулгүй ажиллагааны дагуу засаж тохижуулсан байдал

1.3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

2022 онд төслийн талбайн сул чөлөөтэй талбайд монос, нарс, агч, өрөл, хайлаас тарималжуулах ажлыг хийсэн. Агрохимич ажилуулж зөвлөгөө авч ажилласан. Амрагчдын сууцуудыг холбосон зам талбайг хатуу хучилттай болгох, орчны цэвэрлэгээг тогтмол хийж гүйцэтгэсэн болно.

2022 онд хэрэгжүүлсэн орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт:

БОМТ тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Биелэлт	Зардал, төгрөг	Төсөл хэрэгжүүлэгч, /хамтран хэрэгжүүлсэн/
Сул чөлөөтэй талбайг тарималжуулах, ногоон байгууламж байгуулах.	Нарс – 10 ш Агч – 25 ш Монос – 8 ш Өрөл – 3 ш Хайлаас – 1100 ш зэрэг мод, бутыг суулгах, тарималжуулах, арчилах ажлыг хийсэн.	12,413,000	“Мандах консалтинг” ХХК Агрономичтой хамтарсан.
Амрагчдын сууцуудыг холбосон зам талбайг хатуу хучилттай болгох	Амрагчдын сууцуудыг холбосон замыг хатуу хучилттай болгосон.	10,000,000	“Мандах консалтинг” ХХК
Төслийн талбай болон түүний орчмын цэвэрлэгээг тогтмол хийх	Төслийн талбай болон түүний орчмын цэвэрлэгээг тогтмол хийсэн.	200,000	“Мандах консалтинг” ХХК
Нийт		22,613,000 төгрөг	




Зураг 19. Мод, сөөгний суулгац буулгасан байдал, шинээр тарималжуулалтыг ажлыг гүйцэтгэсэн байдал /Хайлаас/



Зураг 20. . Мод, сөөгний суулгац буулгасан байдал, шинээр тарималжуулалтыг ажлыг гүйцэтгэсэн байдал /бусад мод, бут/



Зураг 21. Амрагчдын сууцуудыг холбосон хатуу хучилттай зам байгуулсан байдал





Зураг 22. Төслийн талбай болон түүний орчмын цэвэрлэгээг тогмол хийх

1.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төслийн талбай нь бусад газар ашиглагч нарын зөвшөөрөл бүхий газартай давхцалгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй болно.

1.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Тус төслийн талбай орчимд одоогийн байдлаар түүх, соёлын дурсгал, археологи, палеонтологийн олдвор илрээгүй болно. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сумын засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжыг мөрдөж ажиллах болно.

1.6. Хог хаягдлын менежментийн биелэлт

Хог хаягдлын менежментийн биелэлт:

БОМТ тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Биелэлт	Зардал, төгрөг	Төсөл хэрэгжүүлэгч, /хамтран хэрэгжүүлсэн/
Аялал жуулчлалын улирал дуусах үед эдэлбэр газар, түүний эргэн тойрны хариуцан хамгаалах талбайн цэвэрлэгээг хийх	Аялал жуулчлалын улирал дуусах үед эдэлбэр газар, түүний эргэн тойрныг хариуцан талбайн цэвэрлэгээг хийдэг.	Өөрсдийн ажиллах хүчийг ашигладаг.	“Мандах консалтинг” ХХК
Хог түр хадгалах цэгт цугларсан хогийг тогтмол хугацаанд зөвшөөрсөн цэгт тээвэрлүүлж байх	Хог хаягдал түр хадгалах цэгт цуглуулж, хогийг тогтмол хугацаанд гэрээний дагуу зөөвөрлүүлэн зайлуулж	Хог хаягдал тээвэрлэн зайлуулах гэрээнд заасны дагуу төлбөрийг	“Мандах консалтинг” ХХК Налайх дүүргийн ТҮК

	байна.	төлдөг.	
Хог хаягдлын талаар амрагч, ажилчдад мэдээлэл түгээх, танилцуулга хийх	Хог хаягдлыг ангилан ялгах талаар амрагч, ажилчдад мэдээлэл, танилцуулга хийж ажилладаг.	0,0	“Мандах консалтинг” ХХК
Төслийн ахуйн бохир ус татан зайлуулах гэрээ орон нутгийн холбогдох байгууллагатай байгуулах, тогтмол хугацаанд байгаль орчны бохирдол үүсгэхгүйгээр зайлуулах	Төслийн ахуйн бохир ус татан зайлуулах гэрээ орон нутгийн холбогдох байгууллагатай байгуулж, тогтмол хугацаанд гэрээний дагуу зайлуулж байна.	Бохир ус зайлуулах гэрээнд заасан төлбөрийг төлдөг.	“Мандах консалтинг” ХХК
Ахуйн хатуу хог хаягдлын түр цэг байгуулахдаа хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савыг хаягжуулах	Ахуйн хатуу хог хаягдлын түр цэг байгуулахдаа хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савыг хаягжуулсан.	100,000	“Мандах консалтинг” ХХК
Нийт		100,000 төгрөг	




Зураг 23. Ахуйн хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг, битүүмжилсэн байдал



Зураг 24. Ахуйн хатуу хог хаягдлын түр цэг байгуулахдаа хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савнууд, хаягжуулсан байдал



Зураг 25. Төслийн талбай болон түүний орчмын цэвэрлэгээг хийж буй байдал



20...оны 06 сарын 02 өдөр

№ 11

Налайх дүүрэг

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ЗОРИЛТ: Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх харилцааг зохицуулах, аж ахуйн нэгж байгууллага, ХХЭрхлэгч нэг бүрийн үүрэг хариуцлагыг тодорхойлж дүгнэх, Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Нийслэлийн ИТХ-ийн Тэргүүлэгчдийн 2009 оны 63-р тогтоолоор батлагдсан “Хот тохижилт, цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дагаж мөрдөх журам”, “Журамд өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн ИТХ-ийн 2012 оны 61-р тогтоол, Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөнчийн Хурлын 2021 оны 07/02 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд оршино.

Энэхүү гэрээг нэг талаас “Тохижилт Үйлчилгээ” ОНӨААТҮГ-ыг төлөөлж, *С.Очиртөгви* ААН-ийг төлөөлж *Г.С.А.Урал* бид харилцан тохиролцож 2022 оны 06 сарын 02-ны өдрөөс *1* жилийн хугацаатай байгуулав.

НЭГ: “ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨААТҮГ-ЫН ЭРХ ҮҮРЭГ

1. Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн өөрийн тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн сар бүр тогтмол өөрийн тээврийн хэрэгслэлээр түрж булах.
2. Хог тээвэрлэлтийн талаарх санал гомдлыг хүлээн авч тухай бүр нь шуурхай шийдвэрлэж байх.
3. Хог хаягдлын төлбөрийн төсөвт төвлөрүүлсэн дарууд хөнгөн шуурхай үйлчилж тогтоосон хугацаанд хогийг тогтмол дарж устгаж байх.

ХОЁР: ГЭРЭЭТ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЭРХ ҮҮРЭГ.

1. Хог хаягдлыг агуулах тусгай тагтай савтай байх, хогоо хогийн цэгт заасан байршилд гаргаж асгаж байх, ил задгай асгах шатаах зэргээр орчин бохирдуулахгүй байх.
2. Дүүргийн ЗДТГ-аас хариуцуулсан болон өөрийн орчны газрынхаа хог хаягдлыг байнга цэвэрлэх болон хог хаягдлыг зайлуулах олон нийтийн ажилд оролцож байх.
3. Хог тээвэрлэлтийн талаарх санал гомдлоо холбогдох байгууллагуудад гаргаж шийдвэрлүүлэх.

ГУРАВ: ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

1. Хог тээврийн дундаж км 1 удаагийн ачилтын үнэ НИЙТ байна. Гэрээний хугацаанд энгийн хог хаягдлыг 30 хоногт удаа байна. Нэмэлтээр ачуулсан тохиолдолд нэмэгдэл төлбөрийг төлнө.
2. Үйлдвэрийн гаралтай (аюултай хог хаягдал, барилга, малын гаралтай) хог хаягдлыг тусгай зориулалтын хог тээврийн авто машинаар нэмэлт төлбөрөөр ачиж тээвэрлэнэ.
3. Хог хаягдлын тухай хуулийн 10.2.3. дахь заалтын дагуу хог хаягдал гаргасан төлбөр төгрөгийг удаа бэлэн бусаар Налайх Тохижилт үйлчилгээ *Г.С.А.Урал*

ОНӨААТҮГ-ын ХААН банк 5749062084 тоот дансанд “Хог түрэлтийн хураамж” тушааж мөнгө тушаасан баримтыг үндэслэн хог хаягдлыг тээвэрлэнэ.

ДӨРӨВ: ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

1. Хог тээврийн гэрээ байгуулахгүй, зориулалтын бус газар хог хаягдал хаясан аж ахуйн нэгж, байгууллагыг Хог хаягдлын тухай хуулийн 22.4.2 дугаар заалтын дагуу 150000-250000 төгрөгөөр торгоно.
2. Эрүүл ахуйн тухай хуулийн 22.1.2-т зааснаар энэ хуулийн 4.3.1, 4.3.2, 4.4.1, 4.4.2, 5.2, 5.3, 6.2, 7.1, 7.4, 8.2, 20.1.2, 20.1.3-т заасныг зөрчсөн бол хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, албан тушаалтныг Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөс гурван сая төгрөгөөр хяналтын байгууллагын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч торгож, үйл ажиллагааг нь зогсоох 22.2-д зааснаар Энэ хуулийн 4.4.3, 4.4.4-т заасныг зөрчсөн бол хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сая төгрөгөөс хоёр сая төгрөгөөр сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга торгох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.


ГЭРЭЭ ХИЙСЭН


НАЛАЙХ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ ТӨЛӨӨЛЖ
 ОНӨААТҮГ-ЫГ ТӨЛӨӨЛЖ
 О.Очирзориг / 96561250
 Ч.А.Э. Түвшин / 5749062084

Зураг 26. Хог хаягдлын гэрээний хуулбар

Системийн огноо/System Date: 2022.07.26				
Дт	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5070 535 108	МАНДАХКОНСАЛТИНГ	880,000.00 MNT	1.00
/ найман зуун наян мянган төгрөг /				
Кт	Банкны дугаар/Branch No	Банкны нэр/Bank Name	880,000.00 MNT	1.00
	Дансны/Картын дугаар Account/Card Number	Нэр/Name		
	5749 872 758	СҮРЭН ОЮУНГЭРЭЛ		
Гүйлгээний утга/Transaction description: ЕВ-5511119 Мандах Консалтинг хог 7/23 хүртэлх				
Системийн огноо/System Date: 2022.09.01				
Дт	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5070 535 108	МАНДАХКОНСАЛТИНГ	660,000.00 MNT	1.00
/ зургаан зуун жаран мянган төгрөг /				
Кт	Банкны дугаар/Branch No	Банкны нэр/Bank Name	660,000.00 MNT	1.00
	Дансны/Картын дугаар Account/Card Number	Нэр/Name		
	5749 062 084	НАЛАЙХТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ		
Гүйлгээний утга/Transaction description: ЕВ-5511119 Мандах Консалтинг ХХК хогны тооцоо				

Зураг 27. Хог хаягдал зайлуулах үйлчилгээний төлбөрийн баримт





Зураг 28. Бохир ус зайлуулах гэрээний хуулбар

Системийн огноо/System Date: 2022.05.31				
Дт	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5070 535 108	МАНДАХКОНСАЛТИНГ	250,000.00 MNT	1.00
/ хоёр зуун тавин мянган төгрөг /				
Кт	Банкны дугаар/Branch No	Банкны нэр/Bank Name		
	5027 932 379	БАТ ХАН ОРГИЛ	250,000.00 MNT	1.00
Гүйлгээний утга/Transaction description: ЕВ-5511119 Мандах Консалтинг ХХК Бохир				

Системийн огноо/System Date: 2022.06.28			
Дт	Дансны/Картын дугаар Account/Card number 5070 535 108	Нэр/Name МАНДАХКОНСАЛТИНГ	Дүн/Amount 500,000.00 MNT
	/ таван зуун мянган төгрөг /		Ханш/Rate 1.00
Кт	Банкны дугаар/Branch No 15	Банкны нэр/Bank Name - Голомт	Дүн/Amount 500,000.00 MNT
	Дансны/Картын дугаар Account/Card Number 1605 192 305	Нэр/Name Хашын Хишигтэн ХХК	
Гүйлгээний утга/Transaction description: ЕВ-5511119 Мандах Консалтинг ХХК бохир			
Системийн огноо/System Date: 2022.06.21			
Дт	Дансны/Картын дугаар Account/Card number 5070 535 108	Нэр/Name МАНДАХКОНСАЛТИНГ	Дүн/Amount 700,000.00 MNT
	/ долоон зуун мянган төгрөг /		Ханш/Rate 1.00
Кт	Банкны дугаар/Branch No 15	Банкны нэр/Bank Name - Голомт	Дүн/Amount 700,000.00 MNT
	Дансны/Картын дугаар Account/Card Number 5027 932 379	Нэр/Name БАТ ХАН ОРГИЛ	
Гүйлгээний утга/Transaction description: ЕВ-5511119 Мандах Консалтинг ХХК бохир			
Системийн огноо/System Date: 2022.06.17			
Дт	Дансны/Картын дугаар Account/Card number 5070 535 108	Нэр/Name МАНДАХКОНСАЛТИНГ	Дүн/Amount 675,000.00 MNT
	/ зургаан зуун далан таван мянган төгрөг /		Ханш/Rate 1.00
Кт	Банкны дугаар/Branch No 15	Банкны нэр/Bank Name - Голомт	Дүн/Amount 675,000.00 MNT
	Дансны/Картын дугаар Account/Card Number 5009 952 783	Нэр/Name МАРГАД ЭРДЭНЭ УУЛ	
Гүйлгээний утга/Transaction description: ЕВ-5511119 Мандах Консалтинг ХХК бохир			
Системийн огноо/System Date: 2022.06.07			
Дт	Дансны/Картын дугаар Account/Card number 5070 535 108	Нэр/Name МАНДАХКОНСАЛТИНГ	Дүн/Amount 500,000.00 MNT
	/ таван зуун мянган төгрөг /		Ханш/Rate 1.00
Кт	Банкны дугаар/Branch No 15	Банкны нэр/Bank Name - Голомт	Дүн/Amount 500,000.00 MNT
	Дансны/Картын дугаар Account/Card Number 5027 932 379	Нэр/Name БАТ ХАН ОРГИЛ	
Гүйлгээний утга/Transaction description: ЕВ-5511119 Мандах Консалтинг ХХК бохир			

Зураг 29. Бохир ус зайлуулах үйлчилгээний төлбөрийн баримт

2.1. 2022 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Биелэлт	Зардал, төгрөгөөр	Хариуцсан албан тушаалтан
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах	2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ батлуулсан.	Гэрээний нөхцөлөөр	Төслийн менежер
Байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, зардлыг тооцож, тухайн жилийн үйл ажиллагааны зардалд тусгаж өгөх	Удирдлагын зүгээс тогтмол дэмжин ажилладаг.	Тухайн жилийн БОМТ-нд тусгагдсан зардлын хэмжээгээр	Төслийн удирдлага
Хөдөлмөр хамгааллын анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, анхааруулах самбар байрлуулах	Хөдөлмөр хамгааллын анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, анхааруулах самбар байрлуулаагүй. 2023 онд хэрэгжүүлэх болно.	0,0	Төслийн менежер

Газар, ус, цахилгаан ашигласны болон бусад /хог хаягдал, бохир ус зайлуулсны/ төлбөрийг төлөх	Гэрээнд тусгагдсны дагуу төлбөрийг тогтмол төлж байна.	Дотоод зардлаар	Төслийн менежер
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллах	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжүүлж удирдлагын зүгээс тогтмол хяналт тавьж ажилладаг.	0,0	Төслийн менежер
Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхдээ дүүргийн ТҮК-тэй хийсэн гэрээний дагуу зайлуулах	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхдээ дүүргийн ТҮК-тэй хийсэн гэрээний дагуу зайлуулдаг.	0,0	Төслийн менежер
Нийт			0,0

2.3. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

“Мандах консалтинг” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Горхи ресорт” гэр бүлийн эко аялал жуулчлалын бааз төслийн хүрээнд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу 2022 онд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд ус, агаар, хөрс, ургамлын нөмргийн мониторинг судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт:

ОХШХ-ний цэгүүд	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Биелэлт	Төсөл хэрэгжүүлэгч, /хамтран хэрэгжүүлсэн/
Агаар орчны хяналт шинжилгээ	Агаарын тоос тоосонцор (PM _{2.5} , PM ₁₀)	Эдэлбэр газрын хил дотор 2 цэгт	Хэрэгжүүлсэн	“Мандах консалтинг” ХХК
	Дуу чимээ	Эдэлбэр газрын хил дотор 2 цэгт		“Мандах консалтинг” ХХК
Усан орчны хяналт шинжилгээ	Усны унд-ахуйн хими, физикийн үзүүлэлт	Гүний хугдгийн усанд 1 цэгт	Хэрэгжүүлсэн	“Мандах консалтинг” ХХК Налайх дүүргийн ТҮК
Хөрсөн орчны хяналт шинжилгээ	Ялзмаг агууламж Урвалын орчин Хөрсний физик, химийн шинж чанар Хөрсний хүнд металлын агууламж Нийт азот, фосфор	Эдэлбэр газрын хил дотор 2 цэгт	Хэрэгжүүлсэн	“Мандах консалтинг” ХХК
Ургамлын хяналт шинжилгээ	Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн бичиглэл үйлдэх	Эдэлбэр газрын хил дотор 2 цэгт	Хэрэгжүүлсэн	“Мандах консалтинг” ХХК

Агаарын чанарын хэмжилтийн үр дүн: Төслийн хувьд агаар бохирдуулах гол эх үүсвэр нь төслийн болон төслийн талбайн хажуугаар дайран өнгөрөх тээврийн хэрэгслийн утаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт, үүсэх дуу чимээ зэрэг юм. Агаарын чанарт үзүүлж буй нөлөөллийг тогтоох зорилгоор 2 цэгт хэмжилт хийж, үр дүнг “MNS 4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандартын шаардлагатай харьцуулан Агаарын чанарын индексээр үнэлэх зэрэг аргыг ашиглав.

Хүснэгт 2. Агаарын чанарын хэмжилтийн үр дүн

Хэмжилтийн цэгийн байршил	Үзүүлэлт	Хэмжилт хийсэн хугацаа	Хэмжих нэгж	Стандарт утга	Хэмжилтийн дундаж утга	АЧИ-ийн тоон үзүүлэлт (Im/Is*100)	Агаарын чанар болон өнгөний тэмдэглэгээ
АЧХЦ-01	PM ₁₀	10	мкг/м ³	0-50	5.6	5.6	Цэвэр
	PM _{2.5}	10	мкг/м ³	0-35	4.1	5.85	Цэвэр
	Дуу чимээ	10	дБа	60	44.6		
АЧХЦ-02	PM ₁₀	10	мкг/м ³	0-50	4.5	4.5	Цэвэр
	PM _{2.5}	10	мкг/м ³	0-35	3.3	4.71	Цэвэр
	Дуу чимээ	10	дБа	60	46.7		

Тайлбар: Агаар дахь тоос, тоосонцрын хэмжилтийг нарийн ширхэглэгт тоосонцор (PM_{2.5}), том ширхэглэгт тоосонцор (PM₁₀), агаарын чийгшил, температур гэсэн үзүүлэлтээр Хятад улсад үйлдвэрлэсэн Temtop air quality 1000 багажаар, дуу чимээг С.Е.М. DT- 8820 Америк улсад үйлдвэрлэсэн багажаар 10 минутын турш хэмжилт хийж үр дүнг “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4585:2016” стандартын утгатай харьцуулж агаарын чанарын индекс (АЧИ)-ээр үнэлэв.



Зураг 30. Агаарын чанарын хэмжилтийн хийж буй үеийн зураг

Дүгнэлт: Төслийн талбайд хийсэн агаарын чанарын хэмжилтийн дүнгээр Монгол улсын агаарын чанарын стандарт болох MNS 4585:2016 стандартыг давсан агаар дахь бохирдуулагч бодис байхгүй, төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага гэж үзэж байна. Хэмжилтийн үр дүнгээс харахад агаар дахь том ширхэглэгт тоосонцор 4.5-5.6 мкг/м³-ийн хооронд, нарийн ширхэглэгт тоосонцор 4.71-5.85 мкг/м³-ийн хооронд буюу зөвшөөрөгдөх хэмжээнээс хэд дахин бага үзүүлэлттэй байна. Хэмжилт хийсэн бүх цэгүүдэд орчны дуу шуугианы төвшин хэвийн байна.

Усны шинжилгээний үр дүн: Төслийн амрагчдын болон ажилчдын унд-ахуйн усны хэрэглээг төслийн талбайд байрлах гүний худгаас хангадаг. Энэхүү худгийн усны бактериологи буюу эрүүл ахуйн үзүүлэлтийг тодорхойлуулах зорилгоор “Грийн Лаб” Ус, хөрс судлалын лабораторид шинжлүүлэв.



Зураг 31. Төслийн талбайд байрлах гүнийн худгийн байршил

Хүснэгт 3. Судалгааны талбайн гүний худгийн солбилцол

Дээж авсан цэгийн координат			
Уртраг	107°	21'	43.85"
Өргөрөг	47°	49'	43.85"



Зураг 32. Төслийн талбайд байрлах гүний худаг

Хүснэгт 4. Усны эрүүл ахуйн задлан шинжилгээний дүн

Лабораторын дугаар	Шинжилгээний аргын сиандарт	Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж	Шаардлага	Шинжилгээний хариу
22/3919	MNS ISO 6222:1998	ББЕТ	1 мл-т 100-аас ихгүй	1.0*10 ¹
	MNS ISO 9308-1:1998	Гэдэсний бүлгийн нян	100 мл-т илрэхгүй	илрээгүй
	MNS ISO 19250:2017	Salmonella ssp	25 мл-т илрэхгүй	илрээгүй

Төслийн талбайд гаргасан гүний худгийн ус нь ББЕТ 1.0*10¹ буюу энэ төрлийн нянгаар бохирдоогүй, гэдэсний бүлгийн нян болон Salmonella ssp ирээгүй буюу нянгаар бохирдоогүй ус байна.

Хөрсний шинжилгээний үр дүн: Төслийн талбайд нуга-намгийн цэвдэгт хөрс тархсан байна. Энэ хэвшинжийн хөрснөөс 2 хөрсний зүсэлт хийж дээж авав. Дээжүүдийг хөрсний хими, физик, хөрсөнд агуулагдах зарим металлын агууламж болон эрүүл ахуйн үзүүлэлтийг тодорхойлох зорилгоор “Грийн лаб” Ус, хөрс судлалын лабораторид шинжлүүлэв.



Зураг 33. Хөрсний дээж авсан байдал, зүсэлтийн зураг

Хүснэгт 5. Хөрсний дээж авсан цэг

Цэгийн дугаар	Шинжилгээ хийсэн үзүүлэлт	Солбилцол	
		Өргөрөг	Уртраг
Дээж-1	Хөрсөнд агуулагдах зарим хүнд металлын агууламж, эрүүл ахуйн үзүүлэлт тодорхойлох	47°49'8.12"N	107°21'41.76"E
Дээж-2	Хөрсний хими, физик шинж чанар	47°49'4.74"N	107°21'36.37"E

Лабораторийн задлан шинжилгээний үр дүн:

Хүснэгт 6. Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээжийн нэр	Гүн, см	Механик бүрэлдэхүүн, % (мм-ээр)						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Дээж-2	0-30	33.9	34.5	16.4	1.3	10.5	3.5	15.3

Судалгааны үр дүнгээс үзэхэд нугат-намгийн цэвдэгт хөрсний хөрсний 0-20 см-т физик шаварын агууламж 15.3% буюу элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна.

Хүснэгт 7. Хөрсний химийн шинж чанар

Дээжийн нэр	pH _{N2O} (1:2.5)	Давс, %	Ялзмаг %	EC _{2.5} dS/m	CO ₂ , %	Шимт тэжээлийн элементүүд, мг/100г		Шингээгдсэн сууриуд, мг-экв/100гр		
						P ₂ O ₅	K ₂ O	Ca+Mg	Ca	Mg
Дээж-2	8.09	0.02	1.02	0.045	0.00	1.8	11	18.6	12.4	6.2

Хөрсний шинжилгээний үр дүнгүүдээс үзэхэд хөрсний урвалын орчин (pH) шүлтлэг 8.09 буюу сул шүлтлэг, ургамал ургахад таатай орчин болж өгдөг. Карбонажаагүй (0.00), цахилгаан дамжуулах чанар бага (0.045) буюу давсжилтгүй (0.02), хөдөлгөөнт фосфор (P₂O₅), хөдөлгөөнт кали (K₂O) хангамжаар тааруу (12.8), хөрсний үржил шимийн түвшин сайн, ялзмагийн агууламж 1.02% буюу бага байна.

Хүснэгт 8. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж

Дээжний дугаар	Гүн, см	Хүнд металлын агууламж, мг/кг					
		Ni	Cd	Pb	Zn	Cr	Cu
Дээж-2	0-20	25.9	-	3.6	82.2	19.7	12.2
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ /MNS 5850:2019/		60.0	1.0	50.0	100.0	60.0	60.0

Хөрс судлалын лабораторийн задлан шинжилгээний дүнгээр дээрх 6 төрлийн хүнд элементүүд “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019” стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага буюу бохирдол үүсээгүй байгааг илтгэж байна.

Хүснэгт 9. Хөрсний эрүүл ахуй

Дээжний дугаар	Нянгитийн тоо MNS 63416:2012	Гэдэсний савханцарын титр (E.Coli) MNS 5367:2004			Анаэробын (Cl.perfringens) MNS 6341:2012	
	Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	
Дээж-1	3.0*10 ⁴	1.0	Цэвэр	<0.1	Цэвэр	

ДҮГНЭЛТ

“Мандах консалтинг” ХХК нь “Горхи ресорт” гэр бүлийн эко аялал жуулчлалын бааз төслийн хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9 заалтыг үндэслэн БОАЖ-ын сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлан боловсруулсан.

Уг төслийн хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үр дүнтэй байгаа эсэхийг тогтоох зорилгоор тухайн БОМТ-г боловсруулж, биелүүлэн ажилласан.

2022 онд байгаль хамгаалах арга хэмжээ, орчны тохижилт, хог хаягдлын менежментийн хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд ногоон байгууламж нэмэгдүүлэхэд анхаарч монос, нарс, агч, өрөл, хайлаас зэрэг мод, бутыг суулгах, амрагчдын сууцуудыг холбосон зам талбайг хатуу хучилттай болгох, галын наадмын талбайг тохижуулах, төслийн талбай, түүний орчмын цэвэрлэгээг тогтмол хийх, ахуйн хог хаягдал хуримтлуулах савыг шинэчлэх, ангилан ялгах зориулалтын сав байршуулах, хог хаягдлын гэрээг шинэчлэн хогны төлбөрийг төлөх, газрын төлбөр төлөх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Төсийн үйл ажиллагааны явцад ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэхэд зориулан 2022 онд нийт 28,063,000 (хорин найман сая жаран гурван мянган) төгрөг зарцуулсан болно.

Хүснэгт 10. БОМТ-ний биелэлтийн зардал, 2022 он

Зардлын хэлбэр	2022 он /,төг/
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	4,750,000
Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний зардал	22,613,000
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	100,000
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	0,0
Орчны хяналт шинжилгээний зардал	600,000
Нийт	28,063,000